

АВЛИГА, ХЭЭЛ ХАХУУЛИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН БОДЛОГО, ЖУРАМ

Хариуцагч: Анна Диаз, Комплианс хариуцсан захирал

Хянасан: Ева Аргилес, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан
ерөнхий менежер

Баталсан: Төлөөлөн удирдах зөвлөл

Огноо: 10-р сар 23, 2017

Хувилбар: 3.0

Хэл: Монгол

Зорилго: Дэлхий даяар

1. БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Аплас+ групп нь дараахь амлалт үүргүүдийг хүлээсэн болно. Үүнд::

1. Дэлхий даяар бизнесийн үйл ажиллагаагаа хуулийн дагуу, мэргэжлийн түвшинд, ёс зүйтэйгээр эрхлэх.
2. Аплас+ группийн мэргэжилтнүүд, хамтарсан компанийн түншүүд болон гуравдагч этгээдүүд энэхүү бодлого, журмыг ухамсарлан ойлгож, бизнесийнхээ үйл ажиллагааг группийн нэрийн өмнөөс хуулийн дагуу, мэргэжлийн түвшинд, ёс зүйтэй эрхлэх явдлыг бататган хангах.
3. Авлига, хээл хахууль (өрсөлдөгчдөөсөө урьтан бизнес, худалдааны эрх олж авах зорилго бүхий авлига, хээл хахуулийг мөн хамруулан), ирээдүйн ашиг хонжооны талаар урьдчилан тохиролцсон шан харамж, зүй зохисгүй буюу хууль бус төлбөр, бэлэг сэлт, өглөг хандив өгөх, авах болон төрийн байгууллагын албан тушаалтан, захиалагч, үйлчлүүлэгчид, бусад компанийн захирал, албан хаагч, ажиллагчид, аливаа бусад этгээдийн үйлдэл, хандлагыг өөрийн таалал, сонирхолд нийцүүлэх зүй бус аргуудтай тэмцэх.
4. Бизнес эрхэлж буй улс орнууддаа авлига, хээл хахуулийн эсрэг хууль тогтоомжийг нь дагаж мөрдөх.
5. Энэхүү бодлого, журмыг зөрчсөн аливаа тохиолдлыг ноцтой асуудалд тооцон авч үзэж, шийдвэрлэх.
6. Энэхүү бодлого, журмыг зөрчсөн аливаа тохиолдлыг ноцтой асуудалд тооцон авч үзэж, шийдвэрлэх.

Аплас+ группийн бүх мэргэжилтэн, группийг төлөөлөн ажиллаж буй хамтарсан компанийн түншүүд болон гуравдагч этгээдүүд энэхүү бодлого, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд эл үүргээ зөрчиж группийн бизнестэй ямар нэгэн байдлаар холбоо хамааралтайгаар, шударга бус, үндэслэлгүйгээр ашиг шим эсхүл давуу тал (авлига, хээл хахууль, ирээдүйн ашиг хонжооны төлөө урьдчилан тохиролцсон шан харамж, хууль бус өөр төлбөр) шууд эсхүл шууд бусаар санал болгох, амлах, өгөх, ятгах, хүлээн авахыг хориглоно. Эл бодлого, журмын тухай сургалтад хамрагдах группийн мэргэжилтнүүдийг Хууль тогтоомжийн биелэлт хариуцсан захирал нэр заан томилно.

Бодлого, журмыг зөрчих үйлдлийг Аплас+ групп үл тэвчинэ. Тус бодлого, журам зөрчигдвөл Хууль тогтоомжийн биелэлт хариуцсан захиралд эсхүл Хэлтэс, тасгийн түвшин дэх группийн хууль тогтоомж, дүрэм журмын биелэлт хариуцсан албан хаагчид мэдээлэх ёстой.

Аплас+ групп нь мэдээлэл өгөгчийн эсрэг өс хонзонгийн сэдэлтэй үйлдэл хийхийг хориглох бодлого баримталж, хэрэгжүүлдэг. Эл бодлого, журам зөрчигдсөн эсхүл зөрчил гарсан байж болзошгүй талаар үнэнч шударгаар мэдээлснийх нь төлөө, бодлого, журмын дагуу хамтран ажилласных нь төлөө Аплас+ группийн мэргэжилтнүүдийг өс хонзонгийн сэдэлтэй үйлдэлд өртүүлэхгүй, хамгаалах болно

Тус бодлого, журмын сахин хамгаалагч нь Хууль тогтоомжийн биелэлт хариуцсан захирал бөгөөд түүний хэрэгжилт, биелэлтийн эцсийн хариуцлагыг хүлээнэ. Түүнчлэн бодлого, журмыг группийн хэмжээнд таниулах ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Бодлого, журмын талаар асууж тодруулах зүйл байвал Хууль тогтоомжийн биелэлт хариуцсан захиралтай эсхүл Хэлтэс, тасгийн түвшин дэх Аплас+ группийн хууль тогтоомж, дүрэм журмын биелэлт хариуцсан албан хаагчтай холбоо бариарай.